

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/169/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2026 оны 02 дүгээр сарын 13</p> <p>2026</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: М.Алтантуяа</p> <p>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Даваадорж</p> <p>Утас: 90119422 Цахим хаяг: Davaadorjd@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХГБХХЕГ	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХГБХХГ	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮҮХЭД, ГЭР
БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН
ГАЗРЫН ДАРГА Н.МЭНДБАЯР ТАНАА

2026.02.24 № 2/61
танай _____-ны № _____-т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2025 онд Улсын санхүүжилтээс 2,014,854.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,861,293.2 мянган төгрөгийг зарцуулж улсын төсөвт 153,561.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас “Хүүхэд хамгааллын тухай” хуульд заасны дагуу Баянхонгор аймгийн 20 сум, болон аймгийн төвийн 10 баг тус бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг орон тоог шинээр нэмэгдүүлсэн байна.

6426050183

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 98.1 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	123,988,648.3	114,179,758.3
35	БАРАА МАТЕРИАЛ	123,988,648.3	114,179,758.3
351	Түүхий эд материал	6,011,400.0	7,071,000.0
35110	Тусгай зориулалттай материал	5,496,400.0	6,556,000.0
35130	Эм боох материал	515,000.0	515,000.0
354	Хангамжийн материал	117,977,248.3	107,108,758.3
35410	Бичиг хэргийн материал	2,457,670.0	1,600,240.0
35420	Аж ахуйн материал	24,394,378.3	24,943,618.3
35440	Түлш, шатах тослох материал	267,300.0	00.0
35470	Бусад хангамжийн материал	90,857,900.0	80,564,900.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	454,590,089.8	606,144,026.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	454,590,089.8	606,144,026.5
392	Биет хөрөнгө	374,735,089.6	526,344,026.5
39201	Барилга, байгууламж, орон сууц	268,144,869.8	389,578,147.8
39202	Хуримтлагдсан элэгдэл	-51,652,741.4	-67,178,670.1
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,965,000.0	34,965,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,023,416.5	-23,520,416.5
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	161,710,952.0	200,827,415.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-106,620,123.2	-83,381,681.4
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	153,166,447.5	158,333,657.5
39208	Хуримтлагдсан элэгдэл	-87,238,128.7	-104,349,929.6
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,175,895.0	33,175,895.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,058,631.8	-13,270,358.2
39217	Ном	1,164,967.0	1,164,967.0
393	Биет бус хөрөнгө	79,855,000.2	79,800,000.0
39301	Програм хангамж	725,000.0	725,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-669,999.8	-725,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	79,800,000.0	79,800,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	578,578,738.1	720,323,784.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.0	3,808,800.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.0	3,808,800.0
413	Өглөг	00.0	3,808,800.0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.0	255,800.0
4136	Бусад өглөг	00.0	3,553,000.0
41361	Байгууллагад төлөх өглөг	00.0	3,443,000.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.0	110,000.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	578,578,738.1	716,514,984.8
51	Засгийн газрын хувь оролцоо	578,578,738.1	716,514,984.8
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	94,718,933.0	94,718,933.0
51101	Өмч: - төрийн	94,718,933.0	94,718,933.0
512	Хуримтлагдсан үр дүн	317,588,718.6	455,812,161.3

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
51210	Өмнөх үеийн үр дүн	317,588,718.6	317,875,914.6
51220	Тайлант үеийн үр дүн	00.0	137,936,246.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	166,271,086.5	165,983,890.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	578,578,738.1	720,323,784.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,816,155,444.5	2,498,386,651.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,772,500.0	198,814,345.0
120	Нийтлэг татварын бус орлого	5,772,500.0	198,814,345.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,721,300.0	198,814,345.0
120009	Бусад орлого	51,200.0	00.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,810,382,944.5	2,299,572,306.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,453,756,600.0	2,014,854,600.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,453,756,600.0	2,014,854,600.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	356,626,344.5	284,717,706.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,325,837.5	36,526,425.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	89,986,610.0	58,037,281.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	221,313,897.0	190,154,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,800,133,836.7	2,360,450,404.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,800,133,836.7	2,360,450,404.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,548,075,920.8	2,170,419,473.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	541,068,649.3	1,144,530,634.3
210101	Үндсэн цалин	453,768,727.2	819,174,825.9
210102	Нэмэгдэл	47,432,985.1	206,455,908.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,578,937.0	75,975,000.0
210104	Урамшуулал	8,288,000.0	42,924,900.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,239,573.8	153,668,646.5
210201	Тэтгэврийн даатгал	50,867,808.1	108,765,318.5
210202	Тэтгэмжийн даатгал	5,309,307.1	11,279,320.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,909,892.2	5,945,747.1
210204	Ажилгүйдлийн даатгал	2,570,058.5	5,492,738.9
210205	Эрүүл мэндийн даатгал	10,582,507.9	22,185,521.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,159,164.0	80,183,369.6
210301	Гэрэл, цахилгаан	5,257,014.0	9,466,745.6
210302	Түлш, халаалт	56,980,110.0	67,057,584.0
210303	Цэвэр, бохир ус	2,922,040.0	3,659,040.0
2104	Хангамж, бараа материалын зардал	7,883,809.9	31,834,254.0
210401	Бичиг хэрэг	1,145,620.0	1,881,720.0
210402	Тээвэр, шатахуун	1,655,589.0	27,120,234.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,194,420.0	1,632,300.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	1,200,000.0	1,200,000.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,688,180.9	00.0
2105	Нормативт зардал	00.0	12,342,000.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.0	130,000.0
210502	Хоол, хүнс	00.0	12,212,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,000.0	490,110.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.0	490,110.0



Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210604	Урсгал засвар	63,000.0	00.0
2107	Томилолт, зочны зардал	00.0	38,977,728.0
210702	Дотоод албан томилолт	00.0	38,977,728.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	810,985,280.5	585,716,451.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	810,514,080.5	584,394,951.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	245,200.0	224,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.0	92,500.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.0	33,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	38,000.0	817,000.0
210807	Газрын төлбөр	155,000.0	155,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,676,443.3	122,676,279.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.0	44,561,961.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,350,000.0	18,138,300.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,326,443.3	59,976,018.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	252,057,915.9	190,030,931.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,186,770.0	19,574,000.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,886,770.0	00.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.0	19,574,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	213,871,145.9	170,456,931.3
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	16,021,607.8	137,936,246.7
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	16,021,607.8	137,936,246.7

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,810,434,144.5	2,299,572,306.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,200.0	00.0
120	Нийтлэг татварын бус орлого	51,200.0	00.0
120009	Бусад орлого	51,200.0	00.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,810,382,944.5	2,299,572,306.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,453,756,600.0	2,014,854,600.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,453,756,600.0	2,014,854,600.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	356,626,344.5	284,717,706.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,325,837.5	36,526,425.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	89,986,610.0	58,037,281.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	221,313,897.0	190,154,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,781,267,339.5	2,286,856,696.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,781,267,339.5	2,286,856,696.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,528,472,965.6	2,096,825,764.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	542,360,389.6	1,142,896,745.4
210101	Үндсэн цалин	281,986,008.0	645,914,329.7
210102	Нэмэгдэл	169,717,765.6	302,945,283.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,174,269.5	115,344,554.4
210104	Урамшуулал	35,482,346.5	78,692,577.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,647,362.5	140,697,950.4
210201	Тэтгэврийн даатгал	45,658,850.5	98,933,925.6
210202	Тэтгэмжийн даатгал	5,247,078.0	10,451,685.1



Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,623,539.0	5,242,052.6
210204	Ажилгүйдлийн даатгал	2,623,639.0	5,188,872.1
210205	Эрүүл мэндийн даатгал	10,494,256.0	20,881,415.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,942,244.0	81,483,369.6
210301	Гэрэл, цахилгаан	5,257,014.0	9,466,745.6
210302	Түлш, халаалт	56,980,110.0	68,357,584.0
210303	Цэвэр, бохир ус	2,705,120.0	3,659,040.0
2104	Хангамж, бараа материалын зардал	7,417,920.0	23,686,792.0
210401	Бичиг хэрэг	2,955,900.0	9,603,700.0
210402	Тээвэр, шатахуун	1,471,500.0	8,538,592.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	994,220.0	1,156,500.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.0	900,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,196,300.0	3,488,000.0
2105	Нормативт зардал	00.0	36,927,028.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.0	220,000.0
210502	Хоол, хүнс	00.0	31,177,028.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.0	5,530,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,754,950.0	759,710.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,577,500.0	759,710.0
210602	Тавилга	894,800.0	00.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	172,800.0	00.0
210604	Урсгал засвар	109,850.0	00.0
2107	Томилолт, зочны зардал	00.0	38,358,800.0
210702	Дотоод албан томилолт	00.0	38,358,800.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	843,000,099.5	568,995,108.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	842,412,699.5	567,678,108.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	245,200.0	00.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	20,100.0	00.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.0	00.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	38,000.0	1,317,000.0
210807	Газрын төлбөр	251,100.0	00.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,350,000.0	63,020,261.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.0	44,761,961.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,350,000.0	18,258,300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	252,794,373.9	190,030,931.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,923,228.0	19,574,000.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,523,228.0	00.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.0	19,574,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	213,871,145.9	170,456,931.3
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	29,166,805.0	12,715,610.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	29,166,805.0	12,715,610.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,166,805.0	12,715,610.0
2200	Дотоод эх үүсвэрээр	29,166,805.0	12,715,610.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,166,805.0	12,715,610.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-29,166,805.0	-12,715,610.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.0	166,556,086.5	301,282,110.7	00.0	562,557,130.3
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.0	00.0	285,000.0	00.0	285,000.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,718,933.0	166,556,086.5	301,567,110.7	00.0	562,842,130.3
C07	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	16,021,607.8	00.0	16,021,607.8
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.0	166,271,086.5	317,588,718.6	00.0	578,578,738.1
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.0	166,271,086.5	317,588,718.6	00.0	578,578,738.1
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.0	00.0	287,196.0	00.0	287,196.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,718,933.0	166,271,086.5	317,875,914.6	00.0	578,865,934.1
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.0	-287,196.0	00.0	00.0	-287,196.0
D08	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	137,936,246.7	00.0	137,936,246.7
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.0	165,983,890.5	455,812,161.3	00.0	716,514,984.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,087,440,400.0	1,861,293,192.4	226,147,207.6	89.2
Улсын төсвөөс санхүүжих	2,087,440,400.0	1,861,293,192.4	226,147,207.6	89.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,087,440,400.0	1,861,293,192.4	226,147,207.6	89.2
Ажиллагчидтай холбогдсон зардал	1,361,497,600.0	1,253,531,215.8	107,966,384.2	92.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,210,640,300.0	1,114,163,795.4	96,476,504.6	92.0
Үндсэн цалин	655,839,800.0	645,914,329.7	9,925,470.3	98.5
Нэмэгдэл	290,468,700.0	274,212,333.8	16,256,366.2	94.4
Унаа хоолны хөнгөлөлт	137,713,700.0	115,344,554.4	22,369,145.6	83.8
Урамшуулал	126,618,100.0	78,692,577.6	47,925,522.5	62.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,857,300.0	139,367,420.4	11,489,879.6	92.4
Тэтгэврийн даатгал	102,766,300.0	97,603,395.6	5,162,904.4	95.0
Тэтгэмжийн даатгал	12,023,600.0	10,451,685.1	1,571,914.9	86.9
ҮОМШӨ-ний даатгал	6,021,700.0	5,242,052.6	779,647.4	87.1
Ажилгүйдлийн даатгал	6,008,800.0	5,188,872.1	819,927.9	86.4
Эрүүл мэндийн даатгал	24,036,900.0	20,881,415.1	3,155,484.9	86.9
Бараа, үйлчилгээний урсгал зардал	717,830,400.0	588,187,976.6	129,642,423.4	81.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,429,000.0	81,483,369.6	3,945,630.4	95.4
Гэрэл, цахилгаан	9,396,600.0	9,466,745.6	-70,145.6	100.7
Түлш, халаалт	69,546,200.0	68,357,584.0	1,188,616.0	98.3
Цэвэр, бохир ус	6,486,200.0	3,659,040.0	2,827,160.0	56.4
Хангамж, бараа материалын зардал	44,656,200.0	20,198,792.0	24,457,408.0	45.2
Бичиг хэрэг	15,583,900.0	9,103,700.0	6,480,200.0	58.4
Тээвэр, шатахуун	20,555,600.0	8,538,592.0	12,017,008.0	41.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,842,000.0	1,156,500.0	685,500.0	62.8



Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Ном, хэвлэл	4,988,600.0	500,000.0	4,488,600.0	10.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,076,900.0	900,000.0	176,900.0	83.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	609,200.0	0.0	609,200.0	0.0
Нормативт зардал	27,404,000.0	17,690,928.0	9,713,072.0	64.6
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,489,700.0	220,000.0	4,269,700.0	4.9
Хоол, хүнс	14,961,900.0	11,940,928.0	3,020,972.0	79.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,952,400.0	5,530,000.0	2,422,400.0	69.5
Эд хогшил, урсгал засварын зардал	1,700,500.0	0.0	1,700,500.0	0.0
Багаж, техник, хэрэгсэл	746,000.0	0.0	746,000.0	0.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	197,000.0	0.0	197,000.0	0.0
Урсгал засвар	757,500.0	0.0	757,500.0	0.0
Томилолт, зочны зардал	52,209,200.0	38,358,800.0	13,850,400.0	73.5
Дотоод албан томилолт	52,209,200.0	38,358,800.0	13,850,400.0	73.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	447,021,900.0	411,997,787.0	35,024,113.0	92.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	444,877,100.0	410,680,787.0	34,196,313.0	92.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224,000.0	0.0	224,000.0	0.0
Даатгалын үйлчилгээ	142,400.0	0.0	142,400.0	0.0
Тээврийн хэрэгслийн татвар	138,900.0	0.0	138,900.0	0.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,100.0	0.0	59,100.0	0.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,347,500.0	1,317,000.0	30,500.0	97.7
Газрын төлбөр	232,900.0	0.0	232,900.0	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	59,409,600.0	18,458,300.0	40,951,300.0	31.1
Бараа үйлчилгээний бусад зардал	5,984,800.0	200,000.0	5,784,800.0	3.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	53,424,800.0	18,258,300.0	35,166,500.0	34.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,905,000.0	19,574,000.0	2,331,000.0	89.4
Бусад урсгал шилжүүлэг	21,905,000.0	19,574,000.0	2,331,000.0	89.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,905,000.0	19,574,000.0	2,331,000.0	89.4
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,101,233,000.0	1,861,293,192.4	239,939,807.6	88.6

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	265,745,710.0
УРСГАЛ ЗАРДАЛ	265,745,710.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	265,745,710.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,656,477.7
Нэмэгдэл	26,656,477.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,330,530.0
Тэтгэврийн даатгал	1,330,530.0
Хангамж, бараа материалын зардал	3,488,000.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,488,000.0
Нормативт зардал	19,236,100.0
Хоол, хүнс	19,236,100.0

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эд хогшил, урсгал засварын зардал	13,475,320.0
Багаж, техник, хэрэгсэл	13,475,320.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	156,997,321.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	156,997,321.3
Бараа үйлчилгээний бусад зардал	44,561,961.0
Бараа үйлчилгээний бусад зардал	44,561,961.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	265,745,710.0
Нэмэлт санхүүжилтийн орлого	265,745,710.0
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,449,952.6
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,927,281.0
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	173,368,476.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь хүүхэд хамгаалал, гэр бүл, хүүхэд залуучуудад ээлтэй бодлого хэрэгжүүлж тэднийг хөгжүүлэх таатай орчин бий болгоход оршино гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн Б/01 дугаар тушаалаар тус газрын бүтэц орон тоо, зэрэглэл цалин тогтоолтыг шинэчлэн 24 орон тоотойгоор ажиллахаар баталсан байна.

Тайлант онд сум болон аймгийн төвийн бүх багт хүүхэд хамгааллын нийгмийн ажилтны орон тоог шинээр нэмснээр хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгчдийн тоо нэмэгдэж, хамгааллын тогтолцооны хүртээмж, цар хүрээ өссөн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн ХГБХХГ нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь ХГБХХГ-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 05-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт”-ыг үйл ажиллагаандаа ашиглан дагаж мөрдөж байгаа ба холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн ХГБХХГ нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 141,745.0 мянган төгрөг буюу 24.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	123,988.6	114,179.8	(9,808.9)
Үндсэн хөрөнгө	454,590.1	606,144.0	151,553.9
Хуримтлагдсан элэгдэл	(278,263.0)	(292,426.1)	(14,163.0)
Нийт хөрөнгө	578,578.7	720,323.8	141,745.0
Өр төлбөр	(0.0)	3,808.8	3,808.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	578,578.7	716,515.0	137,936.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	578,578.7	720,323.8	141,745.0

Эх сурвалж: Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл тайлант оны эцэст 114,179.8 мянган төгрөг болж, өмнөх үеэс 9,808.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Төсвийн хөрөнгөөр 209,242.2 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, нийт 209,242.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна

Тайлант онд цаашид ашиглах боломгүй болсон 13,254.1 мянган төгрөгийн материалыг газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/149 дугаар тушаалаар акталж устгасан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 606,144.0 мянган төгрөг болж 151,553.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 9/60 дугаар тогтоолоор 49,577.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хасаж, ХГБХХЕГ-ын даргын 2025 оны А/178, А/222 дугаар



Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан тушаалаар тус газарт 82,206.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, Аймгийн ИТХ-ын 2025 оны 10/77 дугаар тогтоолоор 121,433.3 мянган төгрөгийн хүүхдийн зуслангийн спортын талбайг тус тус үнэ төлбөргүй шилжүүлж авсан нь үндсэн хөрөнгө өсөхөд голлох нөлөө үзүүлсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,808.0 мянган төгрөг болж өмнөх оноос 3,808.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрөөс суутгасан 10 хувийн ХХОАТ-ыг оны эцэст бөөн дүнгээр шилжүүлэхээр хүлээгдэж байсан боловч (210801) дансны эрх нээгдээгүйгээс шалтгаалан 3,443.0 мянган төгрөгийн өр үүсэж, энэ нь өглөгийн дансны өсөлтөд голлон нөлөөлсөн байна. Мөн шуудан холбооны өглөг 255.8 мянга, хувь хүмүүст өгөх өглөг 110.0 мянга нийт 365.8 мянган төгрөгийн өглөг төсвийн эрх нээгдээгүйгээс шалтгаалан үүсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 720,323.8 мянган төгрөг болж 137,936.2 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны үр дүн 137,936.2 мянган төгрөгтэй холбоотой байна.

Тус байгууллага нь "Санхүүгийн тооцоолох групп" ХХК -ны санхүүгийн тайлангийн Acolous нэртэй санхүүгийн тайлангийн 1, нярвын тайлангийн 1 нийт 2 нэр төрлийн программ хангамжийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Анхны гэрээний үнэ тус бүр 450.0 мянган төгрөг бөгөөд байгууллагын биет бус хөрөнгөнд бүртгэлтэй байна. Тайлант онд нийт 735.0 мянган төгрөгийн хөгжүүлэлттэй холбоотой зардал гарсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,844,092.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,844,092.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 501,205.5 мянган төгрөгөөр бууруулж 2,342,887.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Баянхонгор аймгийн ХГБХХГ-нь улсын төсвийн санхүүжилт 2,014,854.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,861,293.2 мянган төгрөгийг зарцуулж улсын төсөвт 153,561.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,861,293.2 мянган төгрөг буюу 88.6 хувьтай байна.

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Цалин болон нэмэгдэл урамшууллын зардлаас 96,476.5 мянга, ажил олгогчийн НДШ-ийн зардлаас 11,489.9 мянга, хангамж материалын зардлаас 24,457.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжаас 35,024.1 мянга, бараа, үйлчилгээний бусад зардлаас 40,951.0 мянган төгрөгийг тус тус зарцуулаагүй нь зардлын гүйцэтгэл бүрэн биелэхгүй үлдэхэд голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	801,819.9	772,250.8	-29,569.1	96
2	80102 Туслах үйл ажиллагааны зардал	751,672.2	658,369.2	-93,303.0	88
3	80236 Эрсдэлийн болон НБҮ хийх	27,273.8	19,454.0	-7,819.8	71
4	80237 Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал	160,794.0	105,349.2	-55,444.8	66
5	80238 Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	124,855.2	77,077.7	-47,777.5	62
6	80240 Хүүхдийн хөгжил, оролцоо	126,993.8	121,636.0	-5,357.8	96
7	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	800.0	800.0	0.0	100
8	81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	103,647.2	102,980.5	-666.7	99
9	83115 Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр	3,376.8	3,375.8	-1.0	100
	Нийт дүн	2,101,232.9	1,861,293.2	239,939.7	89

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв. Үүнд:

1. Бүтэц, орон тооны хязгаарыг ХГБХХГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн Б/01 дугаар тушаалаар батлахдаа байгууллагын орон тоог 24 байхаар тогтоосон байна. Гэвч гүйцэтгэлээр нийт 49 орон тоотой ажилласан байна. Орон тоо нэмэгдэх болсон шалтгаан нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас “Хүүхэд хамгааллын тухай” хуульд заасны дагуу сум, хороодод хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс ажиллуулах гэсэн заалтыг үндэслэн ХГБХХГ-ын даргын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 02/661 дугаар албан бичгээр Баянхонгор аймгийн ХГБХХГ нь 2025 оны 02 дугаар сараас эхлэн 20 сум, аймгийн төвийн 10 багт нийт 30 нийгмийн ажилтны орон тоог шинээр нэмэгдүүлэн ажиллуулсан байна.
2. Хоолны хөнгөлөлт нэг өдөрт аймгийн төв 10-15.0 мянган төгрөгөөр тооцож хоолны хөнгөлөлтөд 137,713.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 115,344.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.
3. Тайлант онд урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд нэг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Тодруулбал, Баянхонгор аймгийн МТД телевизтэй 4,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх



мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэн ажилласан бөгөөд гэрээг хугацаанд нь биелүүлж, үр дүнг дүгнэн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

4. Төрд учирсан хохирол, сургалт семинартай холбоотой зардал тайлант онд гараагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Аймгийн ЗДНХ-өөс улсын төсвийн байгууллагуудын албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл хөлс 34,449.6 мянга, дээд шатны төсвийн захирагчаас байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 173,368,000.5 мянган төгрөг нийт 265,855.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 265,745.7 төгрөгийг зарцуулж 110.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогод хүүхдийн зуслан болон хуримын ордны үйл ажиллагааны орлого нийт 173,363.5 мянган төгрөгийг бүрдүүлж зуслан, хуримын ордны үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Баянхонгор аймгийн ХГБХХГ нь өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга Н.Мэндбаяр, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Л.Батнасан нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлын 2,342,887.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,428.9 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 15,228.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж батлагдсан төсвийн 88.6 хувийг зарцуулж 239,939.8 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 307,534.8 мянган төгрөгийн 32 гүйлгээг мэдээлэхээс 5,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүйг аудитын явцад нөхөж мэдээлүүлсэн.

Орлогын 2,237,557.0 мянган төгрөгийн 71 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 107 шийдвэрийг тус тус шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулж мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг “Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар”-ын аудитор Г.Энхзул гүйцэтгэсэн байна. Аудитаар зөрчил илрээгүй өөрчлөлтгүй санал дүгнэлт өгсөн байна

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянхонгор аймгийн ХГБХХГ нь өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөгүйгээр ажилласнаар тайлант онд хүүхдийн зуслан болон хуримын ордны үйл ажиллагаанаас олсон 173,363.5 мянган төгрөгийн орлого нь урьдчилсан зорилт, төлөвлөлтгүй, зөвхөн гүйцэтгэлийн төвшинд зарцуулагдсан байна. Ийнхүү төлөвлөгөөгүй орлого, зарлагын хэрэгжилт нь төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сулруулж, санхүүгийн удирдлагын ил тод байдалд сөргөөр нөлөөлж байгаа тул энэхүү асуудлыг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1 зөрчил илэрснээс, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн.¹

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 15,228.8 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй 3 төрлийн 76,685м² газар байгааг төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад "Өвгөн жаргалант" хүүхдийн зуслангийн 74085 м² газрыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа га-д шилжүүлэн бүртгэсэн боловч тооцооллын алдаа гаргаж 7400 га гэж зөрүүтэй бүртгэсэн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэнтэй нийцэхгүй байна.

"Шийдвэрлэсэн нь: Газрын харилцаа, хот байгуулалтын газартай тооцоо нийлж зөрчлийг арилган хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй 3 төрлийн 76,685м2 газар байгааг төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад "Өвгөн жаргалант" хүүхдийн зуслангийн 74085 м2 газрыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа га-д шилжүүлэн бүртгэсэн боловч тооцооллын алдаа гаргаж 7400 га гэж зөрүүтэй бүртгэсэн байна	1	-	-	-	1	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-

-----oOo-----





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 85/A0571255-БМА-2026/169- Номгон

- МА-СТА -ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил, гэр бүлийн газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй 3 төрлийн 76,685м² газар байгааг төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад "Өвгөн жаргалант" хүүхдийн зуслангийн 74085 м² газрыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа га-д шилжүүлэн бүртгэсэн боловч тооцооллын алдаа гаргаж 7400 га гэж зөрүүтэй бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

6426090267

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

1. Газрын харилцаа, хот байгуулалтын газартай тооцоо нийлж зөрчлийг арилган хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга Н.Мэндбаяр, нягтлан бодогч Л.Батнасан нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Д.ДАВААДОРЖ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно